



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 5/22

Дуурлиг

Хөдөлмөрийн гэрээ цуцалж ажлаас
чөлөөлөх тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 14.3.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн гэрээний 4.3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Манаач Д.Баярсайхан нь 2024 оны 12 дугаар сарын 07 ны өдөр ээлжтэй үедээ архи согтууруулах ундаа хэрэглэж, ажлын байрыг эзэнгүйдүүлж хөдөлмөрийн гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан тул 2024 оны 12 дугаар 10 ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцалж албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Д.Баярсайханы хариуцсан эд хөрөнгийг эд хөрөнгийн жагсаалтаар хүлээн авч, хөрөнгийн тооцоо дуусгахыг нярав Л.Гансүрэнд даалгасугай.

3. Д.Баярсайханы цалингийн тооцоог 2024 оны 12 сарын 09 ний өдрөөр дуусгавар болгохыг байгууллагын нягтлан бодогч Н.Цолмонбаярт зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ

Г.АЗЖАРГАЛ

